



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГА

АЗДТГ-ын байр, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас: 7038 2300, 7038 3303, факс: 7038 1001  
Цахим шуудан: huvsguizdtg@khs.gov.mn  
Цахим хуудас: www.khovsgol.gov.mn

2023.08.04 № 1/1260  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

САНГИЙН САЙД Б.ЖАВХЛАН  
ТАНАА

2024 оны төсвийн төслийн тухай

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 оны төсвийн төсөл, 2025-2026 оны төсвийн төсөөлөл бэлтгэх удирдамжид үндэслэн Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн төсөл, 2025-2026 оны төсвийн төсөөллийг боловсруулан хүргэлээ.

Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн боловсруулсан хүргүүлж буй 2024 оны орлого, зарлагын төсвийн төсөлтэй холбоотой дараах хэд хэдэн асуудалд онцгойлон анхаарч өгөхийг үүгээр уламжилж байна.

**Төсвийн орлого:**

1. Хүн амын орлогын албан татварын хадгаламжийн хүүгийн орлогын албан татварын 2022 оны жилийн төлөвлөгөө 1,798.6 сая төгрөг, гүйцэтгэл 1301.3 сая төгрөг буюу -497.3 сая төгрөгөөр орлого тасарч 72.3 хувийн гүйцэтгэлтэй гарсан. Өмнөх жилүүдийн гүйцэтгэл өндөр байсан боловч 2022 онд иргэд банкнаас хадгаламжаа их хэмжээгээр татах болсон мөн хугацаагүй хадгаламжийн хүүний орлогоос татвар суутгаж авахгүй, хугацаатай хадгаламжийн хүүгийн орлого буурсан зэрэгтэй холбоотой 2024 оны төлөвлөлтийг 2023 оны түвшинд төлөвлөсөн болно.

2. Хүн амын орлогын албан татварын шууд бус орлогын 2022 оны гүйцэтгэл 992.3 сая төгрөг байгаа. Энэ нь 2022 онд "Хангайн торх" ХХК нь хяналт шалгалтанд хамрагдаж суутгаагүй орлогын албан татварт 600.0 сая төгрөг мөн Тариалан сумын "Алтандуулга" ХХК нь хяналт шалгалтанд хамрагдаж суутгаагүй орлогын албан татварт 90.0 сая төгрөг төлсөн зэрэг нэг удаагийн шинжтэй нийт 790.0 сая төгрөг орсон нь гүйцэтгэлийг өндөр болгож байна. Иймд 2024 оны төслийн саналд 300.0 сая төгрөгөөр хянуулах.

3. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар: 2023 онд тус татварын 40 хувь болох жилийн төлөвлөгөө 1,170.0 сая төгрөг, гүйцэтгэл 936.0 сая төгрөг буюу -234.0 сая төгрөгөөр орлого тасарч 80.0 хувийн гүйцэтгэлтэй гарсан бол улсын төсөвт төвлөрүүлэх аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тодотгосон 60 хувь 1,550.0 сая төгрөгөөр, нийт 2720,0 сая төгрөгөөр төлөвлөсөн нь биелэх боломжгүй байдалд хүргэсэн. Энэ тухай Сангийн яаманд удаа дараа тайлбар бичиж хүргүүлсэн боловч хэт өндөрөөр төлөвлөж ийм байдалд хүргэсэн. 2020 оны тус албан татварын улсын төсөвт төвлөрсөн 100 хувийн гүйцэтгэл 943.9 сая төгрөг, 2021 оны улсын төсөвт төвлөрсөн 100 хувийн гүйцэтгэл 1,396.8 сая төгрөг тус тус гарсан бөгөөд Сангийн яамнаас 2023 оны тус орлогын төлөвлөгөөг 845.0 сая төгрөг байхаар баталж ирүүлснийг аймагт биелэх боломжгүй тул 263.0 сая төгрөгөөр бууруулж 582.0 сая төгрөгөөр баталсан, өнөөдрийн байдлаар нэг ч төгрөгийн орлого ороогүй байна. Иймд аж ахуйн

6712030257



нэгжийн орлогын албан татварын аймагт төвлөрөх 40 хувийн орлогыг 2024 онд 506.9 сая төгрөг байхаар хянаж өгөхийг хүсье.

4. Газрын дуудлага худалдаа: 2024 оны аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлагдаагүй байгаа боловч тус орлогыг боломжит түвшинд төлөвлөсөн.

5. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогууд болох газрын төлбөр, байгалийн ургамал ашигласны төлбөр, ус, рашааны нөөц ашигласны төлбөр, ойн нөөц ашигласны төлбөр, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогуудыг байгаль орчны мэдээллийн сан /e.c.mn/-д шивэгдэж, мэргэжлийн байгуулагуудын хянагдсан дүнгээр төлөвлөсөн тул нэмэгдүүлэхгүй хянах.

6. Ногдол ашиг: Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутагт байрлах "Могойн гол" хувьцаат компаниас "Экспортын зориулалтаар нүүрс худалдан борлуулахыг хориглох тухай" аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2019 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоол гарснаар тухайн аж ахуйн нэгжийн ашиг буурсан тул 2024 онд ногдол ашгийн орлогыг төлөвлөх боломжгүй болсон. Мөн орон нутгийн өмчит бусад компаниудын үйл ажиллагааны ашиг бага, алдагдалтай ажиллаж байгаа болон шүүхийн маргаантай асуудлуудын улмаас 2024 онд ногдол ашиг багаар төлөвлөгдснийг анхаарах.

7. Хүүгийн орлого: 2023 оны аймгийн орлогын төлөвлөлтөд дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлт 836.8 сая төгрөг шинээр нэмэгдэж батлагдсан. Тус орлогыг Хөвсгөл-Эрчим хүч" ХХК болон "Хөвсгөл-Ус суваг" ХХК-аас бүрдүүлэхээр аймгийн орлогын төсвийн төсөлд тусган баталсан боловч гүйцэтгэлээр бүрдүүлэх боломжгүй байгааг анхаарч өгөх.

8. Орон нутгийн өмчийн хөрөнгө борлуулсны орлогын 2022 оны гүйцэтгэл 1,268.1 сая төгрөг. Үүнд аймгийн 23 суманд байрлах "Хөвсгөлийн эмийн эргэлтийн сан" орон нутгийн өмчит хувьцаат компанийн эд хөрөнгийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2022 оны тогтоолоор дуудлага худалдаагаар худалдан борлуулахаар үнийн дүнг 717,0 сая төгрөгөөр төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 1,204.0 сая төгрөгт хүрсэн. Энэхүү дуудлага худалдаа нь нэг удаагийн шинжтэй орлого бөгөөд дахин ийм өндөр орлого төлөвлөгдөх боломжгүй тул орон нутгийн өмчийн хөрөнгийн насжилт, элэгдлийн түвшинд үндэслэн 20.1 сая төгрөгийг төлөвлөснийг анхаарч үзэх.

#### **Төсвийн зарлага:**

1. Эрчим хүчний зохицуулах хорооны 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 03 дугаар тогтоолоор Хөвсгөл аймгийн Мөрөн сумын хэрэглэгчдэд мөрдөгдөх дулааны эрчим хүчний тарифыг шинэчлэн тогтоосон. Аймгийн төв Мөрөн суманд үйл ажиллагаа явуулж байгаа, орон нутгийн төсвөөс тогтмол зардал нь санхүүждэг 31 төсвийн байгууллага байгаа бөгөөд энэ нэмэгдсэн тарифаар тооцон үзэхэд жилд 1,1 тэрбум төгрөг шаардлагатай байгааг бүрэн хянаж өгөх.

2. Орон нутгийн нөөц хөрөнгө аймгийн хэмжээнд 300,0 сая төгрөгөөр батлагдан ирсэн бөгөөд 24 суманд хуваарилах, аймагтаа авч үлдэн шаардлагатай зардалд зарцуулах зэрэгт хүрэлцэхгүй байгаа тул бусад аймгуудад хуваарилагдаж байгаа нөөц хөрөнгийн дундажтай харьцуулан нэмэгдүүлж өгөх.

3. Засгийн газрын 2018 оны 267 дугаар тогтоолоор сумын мал эмнэлэг, үржлийн нэгжид өөрчлөлт оруулж сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг баталсан бол Засгийн газрын 2019 оны 88 дугаар тогтоолоор сумын санхүүгийн албаны зохион байгуулалт, чиг үүрэг, орон тооны жишиг нормативыг өөрчилсөн. 2019 оны төсөв батлагдаж ирэхэд сумын Санхүүгийн албанд багтан тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудыг хариуцаж байсан нягтлан бодогчдын орон тоог хассан бөгөөд орон нутгийн байгууллага, сангуудын үйл ажиллагааг хариуцах нягтлан бодогчийн орон тоог эргүүлэн нэмэгдүүлээгүй байдаг. Сангийн яамнаас батлан ирүүлж байгаа орон тооны дээд хязгаарыг барьж сумын Засаг даргын Тамгын газрын бүтэц орон тоог тогтоож байгаа бөгөөд дээрх тогтоолуудыг



үндэслэн, нэмэгдүүлэх шаардлагатай нягтлан бодогч, хөдөө аж ахуйн тасгийн орон тоог бүрэн авч ажиллуулсан нөхцөлд үйлчилгээний ажилтны орон тоог бууруулах шаардлага гарч байгаа нь ихээхэн хүндрэл үүсгэж байна. Иймд сумдын Засаг даргын Тамгын газрын хөдөө аж ахуйн тасаг, Санхүүгийн албаны бүтэц орон тоо, цалингийн санг холбогдох эрх бүхий байгууллагаас гарсан шийдвэртэй нь нийцүүлэн нэмэгдүүлэх.

4. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг ханган “Хүчирхийллийн хохирогчдод үйлчлэх нэг цэг”-ийн үйлчилгээний төвийг 2019 онд байгуулсан бөгөөд 2024 оны үйл ажиллагааны зардалд 141,0 сая төгрөгийг шийдвэрлэх

5. Өсөн нэмэгдэж байгаа хүн ам, өрхийн тооноос хамаарч хог хаягдлын хэмжээ нэмэгдэж байгаа, ажиллагсдын цалин хөлсийг нэмэгдүүлэх шаардлага бий болсон, машин техник шинэчилж чадахгүй байгаагаас шалтгаалан эвдрэл гэмтэл ихэссэн, хотын өнгө үзэмж сайжруулах зорилгоор нийтийн эзэмшлийн талбай нэмж тохижуулж байгаа тул цэвэрлэгээ үйлчилгээ хийх зам талбай ихээхэн нэмэгдэж байгаа зэрэг олон шалтгааны улмаас тул Хот тохижилт үйлчилгээний төвийн зардал хүрэлцэхгүй болсон тул санхүүжилтийг нэмэгдүүлэх.

6. Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6, 14.7 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын хоёр дугаар хавсралтаар баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ыг хэрэгжүүлэн ажиллахад шаардагдах төсвийг шийдвэрлэх, мөн нийслэлийн нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчсон орон нутгийн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн төлбөр, татаасд олгох зардлыг шийдвэрлэх.


7. Монгол Улсын ерөнхийлөгчийн зарлигаар олгогдож байгаа цаатан иргэдийн тэтгэмжийг цаатны тооны өсөлт, амьжиргааны баталгаажих доод түвшинэс өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх

8. Улс орны хэмжээнд хэрэгжиж байгаа Хүнсний хувьсгал, Алсын хараа 2050, улсын болон аймгийн үндсэн чиглэл, үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан гол асуудлыг нэг болох хүнс, тэр дундаа махны чиглэлээр хэрэгжүүлэх “Органик Хөвсгөл - Органик хүнс” арга хэмжээний 2024 онд хэрэгжүүлэх зардлыг Хөтөлбөр, үр дүнд суурилсан төлөвлөлтийн аргаар боловсруулж төлөвлөсөн тул дэмжиж ажиллах зэрэг болно.

Дээр дурдсан саналууд шийдвэрлэгдсэнээр өр авлагагүй ажиллах боломж бий болж, орон нутагт тулгамдаж байгаа олон асуудлууд шийдэгдэн төсвийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагаа хангагдах юм.

Хувийг: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газарт

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ